



ДҮНДГОВЬ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР АЛБАН ШААРДЛАГА

2018 оны 02 дугаар сарын 23

№ 01/57 ДУА-2018/62/СТА-ТШ2 Мандалговь хот

Г

Зөрчил арилгуулах тухай

Т

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2.1-д тодорхойлсон бүрэн эрхийн хүрээнд Дундговь аймаг дахь Төрийн аудитын газрын 2018 оны үйл ажиллагааны төлөвлөгөөний дагуу Дэлгэрцогт сумын Эрүүл мэндийн төвийн 2017 оны жилийн эцсийн санхүүгийн тайлангийн аудитаар **6,256,470.00** /Зургаан сая хоёр зуун тавин зургаан мянга дөрвөн зуун далан/ төгрөгийн дараах зөрчил илэрлээ.

1. Батлагдсан жишиг хэмжээг мөрдөөгүй нийт 5,457,420.00 /таван сая дөрвөн зуун тавин долоон мянга дөрвөн зуун хорин/ төгрөгийн хүнсний материалыг хяналтгүй зарцуулсан.

Энэ нь Эрүүл мэндийн сайдын 2017 оны 2 сарын 23-ны өдрийн А/74 тоот тушаалаар батлагдсан "Хоногийн хоол хүнсээр авбал зохих илчлэг, үндсэн шимт бодис, аминдэм, эрдэс бодисын зөвлөмж хэмжээ"-г зөрчсөн.

2. Хоол хүнсний зардлаас 799,050.00 /долоон зуун сэрэн өсөн мянга тавин/ төгрөгийг шатахуунд зориулалт бусаар зарцуулсан.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 16.5.5 /батлагдсан тосвийг зориулалтын дагуу зарцуулах/ Сангийн сайдын 2014 оны 3 сарын 14-ны өдрийн 55 тоот тушаалаар батлагдсан "Зардлын эдийн засгийн ангилал"-ын "Хоол хүнс- хууль тогтоомжийн дагуу тороос хүнсний бүтээгдэхүүн болон хоолоор хангах үйлчилгээтэй холбогдсон /тухай/балг эмнэлэгт хэвтэн эмчлүүлэгэдийн хоолны зардал, сургалт үйлдвэрлэлийн төвд болон ерөнхий боловсролын сургуулиудын хүүхдийн дотуур байрны хоолны зардал, хугацаат цэргийн албан хаагч, сэхжигтэн хоригдлын хоолны зардал, хий дээр ажиллаж байгаа офицер, ахлагчийн хүнсний хангамжийн зардал гэх мэт/ зардлыг энэ ангилал бүртгэнэ. Энэ зардал нь тухайн байгууллагын үйл ажиллагааны үндсэн үзүүлэлтийн шууд холбоотой эрх бүхий байгууллагаас батлагдсан норм нормативын дагуу төлөвлөгдөж, гүйцэтгэл нь тооцогдоог бөгөөд төлөвлөгөө болон гүйцэтгэлийн хоолны зардлын нийт хэмжээ нь тухайн үйлчилгээг авсан хүний тоотой шууд уялдсан байна./ гэж заасныг тус тус зөрчсөн байна.

Төрийн аудитын тухай хуулийн 15.1.12-т /Аудитын явцад илэрсэн толбор, зорчлийг барагдуулах акт тавих, албан шаардлага өгөх, хууль тогтоомж, эрх зүйн хэмжээс тогтоосон бусад шийдвэрийг боловсронгуй болгох саналыг холбогдох байгууллагад тавих/, Монгол Улсын Ерөнхий аудиторын 2014 оны 138 дугаар тушаалаар батлагдсан Төрийн аудитын байгууллагын ажилтны нийтлэг эрх, үүргийн тухай дүрмийн 2.2.3-т /Төрийн аудитын тухай хуулийн 28 дугаар зүйлийг хэрэгжүүлж хүрээнд төрийн аудитын байгууллагын ахлах аудитор, ахлах шинжээч, аудитор, шинжээч нь аудитын явцад

илэрсэн толборийг барагдуулах, зорчлийг арилгуулах зорилгоор толборийн акт, албан шаардлага огох/, Монгол Улсын Ерөнхий аудиторын 2016 оны 09 дүгээр сарын 09-ны өдрийн А/95 дугаар тушаалаар баталсан Төлбөрийн акт тавих, албан шаардлага өгөхөд баримтлах журмын 4.1.3-д /Төсвийн хоронгийг үр ашиггүй, зориулалт бусаар, батлагдсан хэмжээнээс хэтрүүлэн зарцуулж, Төсвийн тухай хуулийн холбогдох зүйл заалтыг зорчсон/, 4.1.5 /Байгуулсан гэрээ, хэлцэл мөрдож байгаа хууль тогтоомж, дүрэм журмын шаардлага, нохцлийг хангаагүй/ заасныг тус тус үндэслэн ШААРДАХ НЬ:

1. Батлагдсан жишиг хэмжээг баримтлан зарцуулалтыг хийх;
2. Зардлыг зориулалтын дагуу зарцуулах;
3. Албан шаардлагыг хэрэгжүүлж, биелэлтийг аймгийн Төрийн аудитын газарт 2018 оны 03 дугаар сарын 25-ны дотор албан ёсоор ирүүлэхийг Дэлгэрцогт сумын Эрүүл мэндийн төвийн төсвийн шууд захирагч Д.Лувсандагва, нягтлан бодогч Б.Ууганцэрэн нарт хариуцуулав.

АЛБАН ШААРДЛАГЫГ

ӨГСӨН¹:

АУДИТОР



Т.БАТСАЙХАН ЭРХЛЭГЧ

ЗӨВШӨӨРСӨН:

НЯГТЛАН БОДОГЧ



Д.ЛУВСАНДАГВА

Б.УУГАНЦЭРЭН

¹ Акт, албан шаардлагын биелэлт хангаадаагүй тохиолдолд Төрийн аудитын тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.2.2-д "Төрийн аудитын байгууллагаас тавьсан албан шаардлага, тэлбөрийн актыг цаг хугацаанд нь биелүүлээгүй тохиолдолд зөрчил гаргасан албан тушаалтныг үүрэгт ажлаас нь халах тухай саналыг төрийн аудитын байгууллага эрх бүхий албан тушаалтанд хүргүүлнэ" гэж заасны дагуу хариуцагч албан тушаалтанд хариуцлага тооцуулахаар эрх бүхий албан тушаалтанд санал хүргүүлна.